

Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2019 оны 2 сарын мэдээ/

	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт аймгийн дүн
1	Нийт үзлэг	17785	20062	12076	6266	851	57040
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	5792	5679	2538	371	725	15103
3	Идэвхтэй хяналтын үзлэг	2149	3930	2950	526		9555
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	4530	4696	3267	1453	104	14050
5	Нийт төрөлт	178	51				229
6	Хэвтэн эмчлүүлэгчид	1359	885		240	9	2493
7	Нас баралт	5	34	9			48

1. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 57040 хүнд үзлэг шинжилгээ хийсний 43.2%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
2. Ортой эмнэлгүүдэд нийт 2493 хүнийг 16281 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.5 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
3. 2 сарын байдлаар 14050 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9353 тохиолдлоор өссөн байна.
4. Эхний 2 сарын байдлаар 186 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 8 хүн нас барсан нь өнгөрсөн оноос өвчлөл 88 тохиолдол, осол гэмтлийн нас баралт 1-р өссөн байна. Осол гэмтлээр нас барагсдын 50% /4/ нь амиа хорлож, 12,5%/1/ нь зам тээврийн осол, /37,5%/3/ нь ахуйн ослоор тус тус эндсэн байна. Осол гэмтлээр нас барагсад нь бүгд 29-65 насны эрэгтэй хүмүүс эндсэн байна. Мөн ослоор эндэгсдийн 75% нь эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүйн дээр эмнэлэгт нас барсан 2 хүн нь /Хб-өөрийгөө буудсан-1, хөлдсөн-1/ хүнд гэмтлийн улмаас хоног болоогүй нас барсан байна. /Осол гэмтлийн нас баралт-Гт-2/ амиа хорлосон-1, хөлдсөн-1, Мн-амиа хорлосон-1, Но-зам тээврийн осол-1, Сэ-хөлдсөн-1, Хх-амиа хорлосон-1, Хб-2/ амиа хорлосон-1, хөлдсөн-1/
5. Оны гарсаар 48 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 16,6% нь осол гэмтлээр, 29,1% хорт хавдраар, 6,3% зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 6,2% /Хб-1, БОЭТ-2// нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.
6. Нялхсын эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй адил ба 1000 амьд төрөлтөд 17,5 байна.

7. Түргэн тусламжийн 2844 дуудлагад явж үйлчилсний 414/14.5%/ нь алсын дуудлага, 120/4,2%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 95,4% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .
8. 2 сард 3895 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 59,8% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 9 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,1%-г эзэлж байна.
9. Нийт 229 эх төрж 228 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 10 төрөлтөөр хүн амын төрөлт буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна. Нийт төрөлтийн 8,7% охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна/Бу-1,Гт-3,Мн-1,Но-1,Сэ-1,Хб-1,Хх-2,Хү-1,Цц-2,Шб-1,Өо-4,Эх-2/ .
10. 2 сарын байдлаар 75 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 328,9 байгаа нь өнгөрсөн оноос 1,6% өссөн үзүүлэлт байна.
11. Он гараад 69 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 43 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 37,7%-г салхинцэцэг, 7,2%-г улаан эсэргэнэ өвчин, 43,4%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
12. ЭЭСангуудад нийт 3231 жор ирсний 49%/1583/ нь ЭМДаатгалын, 0,2% /7/ мансууруулах эмийн, 2.4% /78/ сэтгэц нөлөөт эмийн, 48.3% /1563/ нь энгийн эмийн жор байсан ба 0,5% /16/нь алдаатай жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 84,2% байна.
13. БОЭТөвд 5 эндэгдэл тохиолдож 1 эндэгдэлийг онош тодорхой, өндөр настан, ар гэрийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар задлан шинжилгээнд хамруулаагүй ба задлан шинжилгээний хувь 100% тай байна. Үндсэн оношийн зөрөө 0%.

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б Мидэрсүрэн , Д. Гантогтох